

Суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломжийг туршин судалсан нь
(*Х дугаар ангийн түүхийн хичээл дээр хос ба олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг ашигласан жишээн дээр*)

*Д.Баяраа, Д.Цэцэгмаа, Н.Наранжаргал, Э.Сувданцэцэг
Ерөнхий боловсролын Үй-Цай сургууль*

Хураангуй

Энэхүү илтгэлдээ суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломж юу байж болох вэ? Олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр нь дээрх боломжийн нэг байж болох уу гэсэн асуудлыг дэвшүүлсэн болно. Энэхүү судалгааны ажил нь: - Улс орнуудын хос болон олон хэл дээрх сургалт, дасгал ажлын дэвтрийн хэрэглээ тэдгээрийн онол, үзэл баримтлал туршлагад тулгуурлан боловсруулсан олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийн даалгавруудад хийсэн анализ, - Багш болон суралцагчдын өөрийн үнэлгээгээр энэхүү олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр нь сурагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэхэд нөлөөлж буй байдал буюу боломжийг илрүүлэх судалгааны үр дүн гэсэн бүрдэл хэсгүүдээр авч үзсэн болно. Уг судалгааны ажлын үр дүнг тооцохдоо: - 2016-2017 оны хичээлийн жилд судалгаат хичээл, сурагчдын сурлагын амжилт, эцэг эхийн хурлын тэмдэглэл, улс орнуудын сургалтын хэрэглэгдэхүүн зэрэгт хийсэн шинжилгээ, дүгнэлт - Сургалтын хэрэглэгдэхүүний танин мэдэхүйн идэвх сонирхол, бүтээлч үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага, төлөв байдлыг илрүүлэх судалгаа - 2017-2018 оны хичээлийн жилийн хос хэл дээрх дасгал ажлын дэвтэр, хүрсэн үр дүнг сурагчдын хэрэгцээ сонирхол, дасгалын агуулга, хэлбэр, түүхэн эх сурвалжийн сонголт, ажиллах нийцэмжтэй байдлыг тогтоох судалгаа - 2018-2019 оны хичээлийн жилийн олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийн дасгалуудаар гүйцэтгэх үйлийн зорилго, чиглэл, эзлэх хувь, дасгалын агуулга, хэлбэр нь цөм хөтөлбөр, суралцахуйн түгээмэл үйлийн 4 бүлэгт нийцэж буй байдал, үр дүнгийн судалгаа, - Олон хэл дээрх дасгал ажлын дэвтрээр суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломжийг илрүүлэх багшийн үнэлгээ, суралцагчдын өөрийн үнэлгээний харьцуулалт зэрэг судалгаануудын үр дүнд дараах дүгнэлтэд хүрлээ. Багш, суралцагчийн үнэлгээний дүнгээс харахад олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр нь суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй цаашид ашиглах боломжтой болох нь харагдаж байна. Дасгалын агуулга, хэлбэр, зааварчилга, суралцахуйн үйл, үнэлгээ, тэдгээрийн шалгуур үзүүлэлт, түүнд тавигдах шаардлагыг сайжруулан энэхүү олон хэл дээрх дасгал ажлын дэвтрээр суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломжийг илрүүлэх судалгааг үргэлжлүүлэх нь үр дүнтэй гэсэн саналыг гаргаж байна.

Түлхүүр үг

Үй-цай боловсрол, хос ба олон хэл, суралцахуйн түгээмэл үйл, дасгал ажлын дэвтэр, дасгалжих дасгал, шинэчлэн өөрчлөх дасгал, туршин судлах дасгал, багшийн үнэлгээ, сурагчийн өөрийн үнэлгээ.

Ерөнхий боловсролын Үй-Цай сургууль нь сургалтын үйл ажиллагаагаа хос (эх хэл-хятад хэл) ба олон хэл (эх хэл-хятад хэл-англи хэл) дээрх Үй-Цай боловсрол хөтөлбөрөөр агуулгын хувьд суурь, ахисан, хөгжүүлэх гэсэн гурван түвшингээр төлөвлөн явуулж байна. Сургалтын үйл ажиллагааны эцсийн үр дүн, суралцагчдын сурлагын амжилтыг сүүлийн 3 жилд танин мэдэхүй, харилцаа, бие хүн, тохируулга-зохицуулалт гэсэн суралцахуйн түгээмэл 4 үйлийн бүлээр хувь хүний хөгжлийн суурь гэж үзэн сургалтын технологийнхоо хөгжлийг дэмжин ажиллаж байна. 2016, 2017, 2018 оны хичээлийн жилүүдэд бид түүхийн хичээлээр хос ба олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг боловсруулан туршилт судалгааг явуулав.

Энэхүү туршилт судалгааны ажил нь дараах зорилго, зорилтыг дэвшүүлэн хэрэгжүүлсэн болно. Үүнд:

Зорилго: Олон хэл дээрх дасгал ажлын дэвтрээр суралцагчдын суралцахуйн танин мэдэхүй, харилцаа, бие хүн, тохируулга-зохицуулалт үйл болон олон судлагдахууны цогц чадамжийг хөгжүүлэх сургалтын олон хэл дээрх хэрэглэгдэхүүнийг буй болгох

Зорилт:

- Дасгал ажлын дэвтэр, хос ба олон хэл, суралцахуйн үйлийн талаарх судлаачдын бүтээлүүдийг судлах
- Суралцагчдын түүхийн хичээл дээрх практик үйл ажиллагааны хэрэгцээ сонирхлыг тогтоох

- Хос хэл дээрх ажлын хуудас боловсруулан туршин судлах
- Олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг боловсруулан туршин судлах
- Судалгааны материалдаа боловсруулалт хийх, дүгнэлт гаргах

Өнөө үед боловсролын салбарт хос болон олон хэл дээрх сургалтыг дэлхийн улс орнууд өөрийн онцлог хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хөгжүүлэх болсноор олон улсын боловсролын байгууллагууд ч анхааран энэ тухай үзэл баримтлалдаа тусгах боллоо (UN News. 24.02.2017).

Энэхүү сургалтыг явуулахдаа олон хэл дээрх мэдээллийг өөр хооронд сөргөлдүүлэн тавих бус тэдний бие биеэ дэмжсэн боломжид нь түшиглэн ажиллах ёстой гэж судлаачид үздэг. Тухайлбал: Крашэн төрөлх хэлээр төлөвшсөн мэдлэг чадваруудыг удаах хэлэнд шилжүүлэн байрлуулж болно гэсэн бол Күминс төрөлх болон удаах хэл нь хоорондоо уялдсан бие биеэ дэмжихүйц нөхцөлтэй (Cummins, 1976, p.9) ба гадаад хэлийг хоёр дахь хэл болгон заахаас гадна уг хэл дээр сургалтыг зохион байгуулснаар хүүхдийн академик төвшнийг чанаржуулж болохыг нотолсон. Блок (Block, 2007), Мүрфиг (Murphy, 2006), Фитс (Fitts, 2006), Фралик (Pralick, 2007) нар хос хэлний боловсролтой хүүхдүүдийн мэдлэг чадвар, амжилт нь ердийн сургуулийн сурагчдаас илүү байгааг тогтоосон байна.

Дээрх судлаачдын онол, үзэл баримтлал нь бидэнд сурагчдынхаа олон хэлний боломжид нь тулгуурлан тэдний бие даасан бүтээлч үйл ажиллагаа, шүүн тунгаах сэтгэлгээ (Загашев & Заир-Бек 2003, л.102), суралцахуйн түгээмэл үйл (Асмолов, Бурменская ба Володарская, 2010. л.4)-ийг хөгжүүлэх хос ба олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг сургалтдаа ашиглах шинэ эрэлт хэрэгцээ, шаардлагын үйдэл, онол үзэл баримтлалын суурь нь болсон юм.

Бид сүүлийн 3 жилийн хугацаанд түүхийн хичээлээр ашиглах хос хэл дээрх ажлын хуудсыг гарган сайжруулж улмаар олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр болгон Үй-Цай боловсрол хөтөлбөрөө хөгжүүлж байна.

2016-2017 оны хичээлийн жилд түүхийн судалгаат хичээл, суралцагчдын сурлагын амжилт, эцэг эхийн хурлын тэмдэглэл, гадаад орнуудын сургалтын хэрэглэгдэхүүний хэрэглээ тэдгээрт анализ хийж дараах дүгнэлтийн хийсэн юм. Үүнд:

- Түүхийн хичээлээр суралцагчид мэдлэгээ бүтээлч үйл ажиллагаа, танил бус нөхцөлд чадвар болгон хэрэглэх буюу

суралцахуйн түгээмэл үйлд суралцах дасгалын хувилбарууд цөөн байгаа

- Ахлах ангийн суралцагчдын эцэг эхийн хурлын тэмдэглэлээс үзвэл сурагчдын гадаад хэлний давуу талыг нь бусад хичээлтэй холбож хэрэглээг нь дэмжсэнээр боловсролын чанарыг нь нэмэгдүүлэх болон хүүхдийн ерөнхий хөгжлийг дэмжиж, сургалтын үйл ажиллагааг сайжруулах

Хөрш улсуудынхаа сургалтын хэрэглэгдэхүүнийг судлан үзвэл сурагчдыг бие даан суралцах, бүтээлч үйл ажиллагаанд сургах дасгал, даалгаврын онол үзэл баримтлал, арга технологийн туршлага бий болж, дасгал ажлын дэвтрийг сонголттой хэрэглэгдэг (-毛瑞方, 2009., 吴梦, 2015., <https://www.euroki.org/gdz/ru/istoriya>) болжээ.

Энэ бүхнээс үндэслэн түүхийн хичээлд ашиглаж байсан сургалтын хэрэглэгдэхүүний танин мэдэхүйн идэвх сонирхол, бүтээлч үйл ажиллагааны хэрэгцээ шаардлага, төлөв байдлыг илрүүлэх үүднээс 9 дүгээр ангийн 50 сурагчдаас хаалтай болон задгай хэлбэрээр асуулга судалгаа авахад:

- Цахим хэрэглэгдэхүүний тухайд судалгаанд хамрагдагсдын 10% нь цахим хичээл нь интернэт орох хүсэл төрүүлдэг,
- хичээл дээр ашигласан ажлын хуудасны тухай “50% нь хичээлийн дараа шууд хаядаг, 20% нь хэсэг хугацааны дараа дэвтрийн дундаас алга болдог” гэж хариулсан. Мөн судалгаанд хамрагдагсдын 95% нь “ажлын хуудас ашиглан заасан хичээл нь ойлгомжтой байдаг” гэсэн бол “дасгал ажлын хуудаснуудыг эмхэтгэн дасгал ажлын дэвтэр болгох нь бидэнд хэрэгтэй” гэж 80% нь хариулсан байна. Харин энэхүү дасгал ажлын дэвтрийн даалгаврууд нь ямар байвал та нарт сонирхолтой, үр дүнтэй бэ? Гэсэн задгай асуултад нийт судалгаанд хамаарагдагсдын 73 хувь санал гаргаснаас “...түүхийн хичээлийг бусад хичээлтэй холбосон, өөрийн сургуулийн онцлог болох хятад, англи хэлний хэрэглээг оруулсан болон өөрийн мэдлэг, үзэл бодлоо ашиглах, сонирхолтой баримт жишээтэй дасгал даалгаврууд...” оруулах гэсэн саналууд их байв.

Дээрх нөхцөл байдлаас дүгнэлт хийж бид 2017-2018 оны хичээлийн жилд өөрсдийн ашиглаж байгаа сургалтын хэрэглэхүүнээ агуулга, бүтэц, хэлбэр, хэрэглээний хүрээнд шинэчлэн сайжруулж, хос хэл дээрх дасгал ажлын

дэвтрийг буй болгон 9 болон 11 дугаар ангиудын түүхийн хичээлд хэрэглэв. Хичээлийн жилийн эцэст дээрх дасгал ажлын дэвтэр ашигласан 138 сурагчдаас тухайн “дэвтрийг ашигласны үр дүнг сурагчдын хэрэгцээ сонирхол, дасгалын агуулгын түвшин, түүхэн эх сурвалжийн материалын сонголт, ажиллах нийцэмжтэй байдал зэргийг тогтоох зорилгоор судалгаа авахад “...95 % нь хэрэглэхэд сонирхолтой байлаа, 80% нь хятад хэл дээрх дасгал даалгаврууд нь эртний хятад хэлээр бичигдсэн сурвалжуудыг ашигласан нь ойлгоход хүндэвтэр, 20% нь даалгаврууд нь их хүнд байсан, 30% нь даалгаврууд нь амархан байна” гэх мэтээр хариулсан байлаа.

Энэ бүхнээс уг дасгал ажлын дэвтрийг “..хятад хэл дээр өгөгдөж байгаа эх сурвалжийг шууд авч ашиглах бус эртний ханз үг хэллэг бичлэгийг өнөөгийн бичгийн хэлэнд хөрвүүлэн хэрэглэж байгаа эх материалаас сонгон оруулах, монгол хэл дээрх эх сурвалжуудыг кирилл ба монгол бичгээр ажиллуулах, түүхэн гэрэл зураг, схем, хэд хэдэн эх сурвалжийг зэрэгцүүлэн ашиглаж бүтээлч үйл хийх, эх зохиох...” зэрэг дасгалаар шинэчлэх шаардлагатай гэж үзлээ. Мөн дасгалын зарим нь хөнгөн, зарим нь хүнд гэх мэтчилэн хариулсныг сурагч хувь хүний хөгжлийн онцлогтой холбоотой гэж үзсэн.


Үүнээс гадна хос хэл дээрх дасгал ажлын дэвтрийг 9-11 ангийн суралцагчдын олон хэлний боломж, өөрийн сургуулийн сургалтын агуулгын гурван төвшний төлөвлөлт зэрэгт нийцүүлэн олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр болгон шинэчлэн өөрчилж болно гэж үзсэн.

2018-2019 оны хичээлийн жилд түүхийн хичээлийн цөм хөтөлбөр болон өөрийн сургуулийн сургалтын онцлогт нийцүүлэн суралцагчдын суралцахуйн дөрвөн бүл үйлд суурилсан олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг боловсруулан 6, 9, 10, 11 дүгээр ангиудын хичээлд хэрэглэж суралцахуйн түгээмэл үйл буюу танин мэдэхүй, харилцаа, тохируулан зохицуулалт, бие хүн гэсэн 4 бүл үйлийг хөгжүүлэх боломжийг дасгалжих дасгал, шинэчлэн өөрчлөх дасгал, туршин судлах дасгалыг ашиглан туршин судалж байна.

Уг туршилт судалгааны ажлын үр дүнгээс авч үзвэл:

Олон хэл дээрх дасгал ажлын дэвтрээр суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх загвар болон дасгалжих, шинэчлэн өөрчлөх, туршин судлах даалгавруудыг дараах загварт үндэслэн боловсруулах оролдлогыг хийсэн болно. Загварыг үзүүлбэл:

Загвар 1
Суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломж.



Энэхүү загварыг сургалтын үйл ажиллагаа талаас нь авч үзвэл орц буюу агуулга нь цөм хөтөлбөрт суурилж, үндсэн мэдлэгийг ахисан ба гүнзгийрүүлсэн түвшинд өргөтгөсөн кирилл, монгол бичгээрх мөн англи, хятад хэл дээрх материалаас бүрдэнэ.

Явц буюу хэрэгжилт нь суралцахуйн түгээмэл дөрвөн бүлэг үйлд суурилсан үйл бүхий дасгалжих, шинэчлэн өөрчлөх, туршин судлах даалгавартай дасгалуудыг гүйцэтгэн танин мэдэхүй, харилцаа, тохируулан зохицуулах, бие хүн гэсэн дөрвөн бүлэг, суралцахуйн үйлийг төлөвшүүлэх зорилгыг хэрэгжүүлэх болно.

Үр дүн нь сургалтын үйл ажиллагааны амжилтыг тухайн судлагдахууны академик мэдлэг, суралцахуйн танин мэдэхүй, харилцаа, тохируулан зохицуулах, бие хүний гэсэн 4 бүлэг үйлийн төлөвшлөөр тооцох боломж буюу олон хэл дээрх дасгал ажлын дэвтрээр сурагчийн суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх зорилго чиглэлийг хэрэгжүүлсэн байхыг тооцож үзсэн болно.

Энэхүү загвар дээр үндэслэн боловсруулсан 10 дугаар ангийн олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг авч үзвэл:

Тус дэвтэр нь цөм хөтөлбөрийн 4 бүлгийн 15 нэгжийн 35 цагийн ээлжит хичээлийн хүрээнд 690 дасгал даалгавраас бүрдэнэ. Дасгалыг гүйцэтгэх үйлийн зорилго чиглэлийн дагуу задлан хүснэгт №1-ээр авч үзвэл:


Хүснэгт 1

Хэл дээрх дасгалын ажлын агуулга, бүтэц

Цөм хөтөлбөрийн агуулга	Дасгалын тоо	Дасгалын хэлбэр																
		Дасгалжих						Шинэчлэн өөрчлөх						Туршин судлах				
		Эх сурвалж дээрх даалгавар						Эх сурвалж дээрх даалгавар						Эх сурвалж дээрх даалгавар				
		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		Монгол хэл дээрх		
Кирилл бичгээр	Монгол бичгээр	Англи хэл дээрх	Хятад хэл дээрх	Бүгд	Бүгд	Кирилл бичгээр	Монгол бичгээр	Англи хэл дээрх	Хятад хэл дээрх	Бүгд	Бүгд	Бүгд	Кирилл бичгээр	Монгол бичгээр	Англи хэл дээрх	Хятад хэл дээрх	Бүгд	
I Бүлэг	118	18	5	1	24	57	4	4	3	68	14	4	2	6	26			
I Бүлэг	168	29	4	2	37	55	4	11	7	15	92	8	6	5	11	9	39	
I Бүлэг	277	51	4	2	59	137	3	8	21	10	179	14	6	2	12	5	39	
I Бүлэг	127	10		4	14	80	2	10	8	100	1	3	5	4	13			
Бүгд	690	108	4	13	9	134	329	7	25	42	36	439	37	12	14	30	24	117

Дасгалыг гүйцэтгэх үүргийн нь зорилго чиглэлээр нь цөм хөтөлбөрийн агуулгад суурилан монгол хэл дээр кирилл, монгол бичгээр мөн англи, хятад хэлэн дээр агуулга бүхий дасгалжих 134, шинэчлэн өөрчлөх 439, туршин судлах 117 гэсэн гурван хэлбэрийн нийт 690 дасгалыг боловсруулан хэрэглэж байгааг үзүүлсэн болно. Нийт дасгалаас дасгалжих дасгал 19%, шинэчлэн өөрчлөх дасгал 64%, туршин судлах дасгал 17%-ыг эзэлж байна. Үүнийг график №1-д харуулав.


График 1
Дасгалын хэлбэрүүд түүний эзлэх хувь



Дасгалын хэлбэрүүдийг цөм хөтөлбөрийн агуулга, бүлэг тус бүрээр нь харгалзуулан авч үзвэл дасгалжих дасгалууд 1 бүлэгт 24, 2 бүлэгт 37, 3 бүлэгт 59, 4 бүлэгт 14 даалгавар шинэчлэн өөрчлөх дасгалууд 1 бүлэгт 68, 2 бүлэгт 92,

3 бүлэгт 179, 4 бүлэгт 100, туршин судлах дасгалууд 1 бүлэгт 26, 2 бүлэгт 39, 3 бүлэгт 39, 4 бүлэгт 13 дасгал тус тус орсон байна. Эдгээрийг график №2-д харуулав.

График 2
Дасгалын хэлбэрүүдийг цөм хөтөлбөрийн агуулгын бүлэг тус бүрээр үзүүлсэн байдал



Эндээс 3 дугаар бүлгийн даалгавар олон, 1, 4 дүгээр бүлгийн даалгавар цөөн байгаа нь цөм хөтөлбөрийн агуулгаас шалтгаалсан болно. Дасгалын гурван хэлбэрээр шинэчлэн өөрчлөх хэлбэрийн даалгаврууд бүлэг тус бүр дээр бусдаасаа олон байна. Харин дасгалжих хэлбэрийн даалгаврууд нь 3 дугаар бүлэгт туршин судлах хэлбэрийн даалгавраас их байгаа бол бусад 3 бүлэгтэй ойролцоо байна.

Энэхүү дасгал даалгавруудыг боловсруулахдаа олон хэл дээрх 216 эх

сурвалжийн даалгавруудыг оруулсан нь нийт дасгал даалгаврын 31%-ийг эзэлж байна. Эдгээрээс 10%- нь англи хэл дээрх, 10%-нь хятад хэл дээрх, 7 %-нь Монгол бичгээрх 4% нь кирилл бичгээрх даалгаврууд байна.

Дасгал бүрийн агуулгын гүйцэтгэх функц буюу чиг үүргийг сурагчдын суралцахуйн түгээмэл үйлийг үндэслэн түүнийг хөгжүүлэх чиглэлээр дасгалжих дасгал нь: “Түүхэн үйл явдлын цаг хугацаа, газар нутаг, оролцогч түүхэн зүтгэлтнийг тодорхойлох, схем гаргах, суурь мэдлэгээ бататгах” зэрэг дасгах үйлийг хийх, шинэчлэн өөрчлөх дасгал нь: “Товч бичиглэл хийх, тоймлон ярих, сэдэвчилсэн хүснэгт зохиох, төлөвлөгөө, график диаграмм гаргах, карт дээр ажиллах, шалтгаан үр дагаврыг тогтоох, бусад үйл явдалтай харьцуулах” зэрэг бүтээлч үйлийг хийх, туршин судлах дасгал нь: “Шинжлэн харьцуулах, бүлэглэн ангилах, бүхлээс жижиг рүү, жижгээс бүхэл рүү дүгнэх, гол хэсгийг тодорхойлж, нотлох, олон өнцгөөс харж бусад сурвалжаар батлах, асуудал дэвшүүлж эрэлхийлэх, өнгөрсөн үеийн түүхэн баримтад үнэлгээ хийх, үндсэн ойлголт нэр томъёог аман бичгээр хэрэглэх, хос ба бүлгээр ажиллах, итгэл үнэмшилтэй болох, бусдаас дэмжлэг авах, дэмжлэг үзүүлэх, хэд

хэдэн эх сурвалж дээр ажиллах, хэлэлцүүлэг хийх” зэрэг өндөр бүтээмжит үйлийг хийхээр тооцоолон боловсруулсан болно.

Сүүлийн жилүүдэд нийгэм болон шинжлэх ухаан, техник технологийн хурдацтай хөгжилтэй уялдан боловсролын салбарт сурагчдаас сургууль дээр олон судлагдахууны чадамжид суралцахыг шаардах боллоо. Ингэснээр сургалтын эцсийн зорилгыг “цогц чадамж болон үйл ажиллагааны арга барил буюу суралцахад сурах” (Горленко, Запятая, Лебединцев и Ушева. 2012, с.153) гэж тодорхойлж байна.

Үүнийг боловсролын салбарт судлаачид суралцахуйн түгээмэл үйл гэсэн ойлголт нэр томъёогоор тэмдэглэн сургалтын үйл ажиллагааныхаа зорилго, хөтөлбөр, технологи, зохион байгуулалтыг боловсронгуй болгох суурь онол үзэл баримтлалаа болгож үзэх (<https://multiurok.ru/index.php/files/formirovaniie-uud-na-urokakh-istorii-i-obshchiestv>) боллоо.

Иймээс суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх зорилго чиглэлийг баримтлан боловсруулсан 3 төрлийн дасгалуудыг 4 бүлд харгалзуулсныг хүснэгт №2-оор авч үзвэл:

Хүснэгт 2

Дасгалуудыг суралцахуйн түгээмэл үйлийн 4 бүлэгт харгалзуулсан байдал

Суралцахуйн түгээмэл үйлдэл	Дасгалын төрөл			Нийт
	Дасгалжих	Шинэчлэн өөрчлөх	Туршин судлах	
Танин мэдэхүй	33	113		146
Харилцааны	39	110	111	260
Зохицуулах	70	216	5	291
Бие хүн	39	110	90	239
Бүгд	181	549	206	936

Эндээс харахад нийт дасгалын 15%-ийг танин мэдэхүйн, 29%-ийг Харилцааны, 31%-ийг зохицуулах, 25%-ийг бие хүний хөгжлийн үйлийг дэмжсэн дасгалууд орсон байна.

Бид 2018-2019 оны хичээлийн жилд 10 дугаар ангийн түүхийн хичээлд олон хэл дээрх дасгал ажлын дэвтрийг сурагчид багшийн зааврын дагуу анги болон гэртээ хэрэглэж, үр дүнг нь өөрөө болон багш үнэлэх, багш суралцагч хамтарсан болон суралцагч бие даасан байдлаар ашиглах хэлбэрээр ажилласан болно. Энэхүү

сургалтын үйл ажиллагаагаар суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг олон хэл дээрх дасгал ажлаар хөгжүүлэх боломжийг илрүүлэх туршилт судалгааг явуулан суралцагч, багш 4 бүлгийн 16 асуулгаар суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийн төлөвшилд нь үнэлгээ хийн зохих дүгнэлтийг хийлээ.

Энэхүү судалгааг 10 дугаар ангийн 2 бүлгийн 50 сурагчдаас авсныг хүснэгт №3-аар харуулбал:

Хүснэгт 3

Суралцахуйн үйлийн төлөвшлийн байдал

	Танин мэдэхүй				Харилцаа					Тохируулга- Зохицуулаг					Бие хүн					Нийт
	0	1	2	Бүгд	0	1	2	Бүгд	0	1	2	Бүгд	0	1	2	Бүгд				
1.1	1	41	8	50	2.1	4	34	12	50	3.1	8	30	12	50	4.1	7	30	13	50	200
1.2	7	32	11	50	2.2	8	23	19	50	3.2	6	34	10	50	4.2	7	30	13	50	200
1.3	9	32	9	50	2.3	3	34	13	50	3.3	5	27	18	50	4.3	6	27	17	50	200
1.4	8	29	13	50	2.4	6	37	7	50	3.4	8	30	12	51	4.4	4	29	17	50	200
бүгд	25	134	41	200		21	128	51	200		27	121	52	200		24	116	60	200	800

Энэ хүснэгтээс үзвэл суралцагчд өөрсдийнхөө танин мэдэхүйн чадварыг 87.5% нь боломжийн сайн, 12.5% нь үгүй, харилцааны чадварын хувьд 89.5% нь боломжийн сайн, 10.5% нь үгүй, зохицуулан тохируулах чадварын хувьд 86.5% нь боломжийн сайн, 13.5% нь үгүй, бие хүний төлөвшлийн хувьд 88 % нь боломжийн сайн, 12% нь үгүй гэж хариулсан бөгөөд нийт судалгаанд хамрагдагсад дээрх 4 бүлэг үйлийн хувьд өөрсдийгөө бүгд 86%-аас дээш хувьтай боломжийн сайн гэж хариулсан нь бидний дасгалууд сурагчдад суралцахуйн түгээмэл үйлийг төлөвшүүлэхэд эергээр нөлөөлж байгааг харуулж байна. Гэхдээ танин мэдэхүйн хувьд “Үйл явдал, түүхэн хүмүүсийн талаар тодорхойлолт хийх”, харилцааны хувьд “Хосоор ажиллахдаа хамтрагчийн санааг хүлээцтэй хандах, дэмжлэг үзүүлэх” тохируулан зохицуулах талаар “Хийх ажлынхаа зорилго, хүрэх үр дүн, дарааллыг тодорхойлох”, “Үйлдлийн алхам бүрийн дүн, ахицыг тооцон үнэлэх” бие хүний хувьд “ Улс үндэсний уламжлал, ёс заншлыг ялган таньж, үнэлэмж өгөх”, “ Тухайн улс үндэстний түүхэн хөгжлийн дэвшил, үнэт зүйлсийг ойлгон үнэлэх” үйлийн хувьд бусдаасаа доогуур үзүүлэлттэй гарчээ.

Энэхүү өөрийгөө үнэлсэн 50 суралцагчдын үнэлгээг харьцуулан баталгаажуулах үүднээс дээрх сурагчдыг тухайн хичээлийг заадаг багшаар үнэлүүлснийг хүснэгт №4-өөр харуулав.

Хүснэгт 4

Багшийн үнэлгээ

Бүгд 50 сурагч	Танин мэдэхүй	Харилцааны	Зохицуулах	Бие хүний
	96	58	63	73


Багшийн үнэлгээнээс танин мэдэхүй, бие хүний суралцахуйн үйл нь боломжийн сайн хэмжээнд үнэлэгдсэн бол харилцааны болон зохицуулах үйлийн талаар доогуур үнэлгээтэй байгаа ч эдгээр нь 58%-аас дээш үнэлгээтэй

байгаа нь эерэг үр дүнтэй болох нь харагдаж байна. Мөн суралцахуйн түгээмэл 4 үйлээрээ бусдаас харьцангуй доогуур буюу нийт 8 оноо авахаас 2 оноо авсан 4 сурагч байна.

Суралцагч болон багшаас авсан судалгааны дүнг харьцуулан график №3-д үзүүлснээс харахад:

График 3

Багш болон суралцагчдын судалгааны дүнгийн харьцуулалт



Багш нь суралцагчдынхаа харилцааны үйлийг 58%, тохируулан зохицуулах үйлийг 63%-тай гэж бусад үйлээс бага оноотой үнэлсэн бол суралцагчид өөрсдийгөө дээрх 4 үйлээр 86-89%-тай хэмээн үнэлжээ. Энэ нь суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийн төлөвшилд олон хэл дээрх дасгал эергээр нөлөөлсөн буюу энэхүү дасгал ажлын дэвтрийн дасгалууд нь суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх нэгэн боломжит хэрэглэгдэхүүний хувилбар байж болох юм гэж үзэж байна.

Дүгнэлт

Дээрх судалгааны үр дүнгээс дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

Улс орнуудад олон хэлний давуу тал, тэдгээр хэл дээрх эх сурвалж материалуудыг сургалтад зэрэгцүүлэн хэрэглэх нь эерэг үр дүнтэй болохыг судлаачид нэгэнт тогтоожээ. Мөн

аливаа судлагдахуунаар дасгал ажлын дэвтрийг хэд хэдэн хувилбараас сонголт хийн хэрэглэдэг туршлага улс орнуудын сургалтын практик үйл ажиллагаанд нэгэнт бий болжээ.

Багш, суралцагчийн үнэлгээний дүнгээс харахад түүхийн хичээлийн олон хэл дээрх дасгал ажлын дэвтэр нь суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэхэд эерэг нөлөөтэй цаашид ашиглах боломжтой болох нь харагдаж байна.

Дасгалын агуулга, хэлбэр, зааварчилга, хөгжүүлэх боломжийг илрүүлэх үнэлгээ тэдгээрийн шалгуур үзүүлэлтэд тавигдах шаардлагыг дээшлүүлэн, дасгалын сонголтыг оновчтой болгосноор суралцагчдын суралцахуйн түгээмэл үйлийг хөгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх талаар цаашид туршилт судалгааг үргэлжлүүлэх хэрэгтэй гэж үзэж байна.

Ном зүй

- Block N.C. (2007). “Dual immersion programs in predominantly Latino schools”, the Claremont graduate university,
- Cummins, J. (1976). The influence of bilingualism on cognitive growth; A synthesis of research findings and explanatory hypothesis. Working paper on bilingualism. 9, 1-43
- Fitts. S. (2006). “Reconstructing the status quo; bilingual and bicultural practices in a dual-language school”, university of Colorado at Boulder,
- Murphy A. (2006). “Dual language programs; Are they an effective model for teaching second language learners?”, st. johns university (new york), school of education and Human Services,
- Pralick P.P. (2007). “A comparative study of fourth-grade English-Language learners who participated in a transitional bilingual model, a dual bilingual model, or English-onle instructiol in a selected south Texas shool district”, University of Houston,
- ЮНЕСКО-гийн ЕНБ-ийн дарга Ирина Бокова. Олон улсын эх хэлний өдрөөр тавьсан илтгэл/ UN News. 24.02.2017
- Асмолов А.Г., Бурменская Г.В., Володарская И.А. и др. (2010). Формирование универсальных учебных действий в Ф79 основной школе : от действия к мысли. Система заданий : пособие для учителя; под ред. А. Г. Асмолова. — М. : Просвещение, — 159 с
- Горленко Н.М., Запятая О.В., Лебединцев В.Б., Ушева Т.Ф. (2012). Структура универсальных учебных действий и условия их формирования // Народное образование. — № 4. — С. 153-160.
- Загашев И.О., Заир-Бек С.И. (2003). Критическое мышление: технология развития. - СПб: Издательство «Альянс «Дельта», - 284с.
- Трифонов А.А. (2016). Диагностика сформированности познавательных универсальных учебных действий школьников. Екатиринбург.
- Формирование УУД на уроках истории и общество здания// <https://multiurok.ru/index.php/files/formirovaniie-uud-na-urokakh-istorii-i-obshchiestv>. Html
- <https://www.euroki.org/gdz/ru/istoriya> - рабочая тетрадь по истории
- 毛瑞方 DUAN RUI FANG. (2009). 中国历史文献学专业外语刍议.// 历史文献研究. №28,
- 吴梦 WU MENG. (2015)初中历史课堂教学语言存在问题及对策研究. //渤海大学. Домайн код: CNKI:CDMD:2.1015.315093
- Баасанжав З. (2010). Түүхийн сургалтын арга зүй. УБ.,
- Байгалмаа Ч. Үйлийн судалгаа. Лекц
- Бурмаа Б., Ганбат Д., (2007). Шинжлэн судлах туршилт явуулж хичээлийн технологийг шинэчлэх арга зүй. Улаанбаатар
- Ванчигсүрэн, Д. (2006). “Хичээлийн технологи, хөтөлбөр, арга зүй”. Улаанбаатар
- Жадамбаа Б, Жонни Балтзерсен. (2008). “Сургалтын чанар түүнийг сайжруулах арга зам”.,
- Жадамба, Б. (2003). Хөтөлбөрийн олон талт тэнцвэрт загвар., Нээлттэй сургууль.,
- Мөнхжаргал, Д. (2016). ХХI зууны чадвар, чадамжийг үнэлэх боломж // Боловсролын үнэлгээ Улаанбаатар. 10-15х.
- Мягмар О., (2003). Хүүхдийн хөгжил. Улаанбаатар
- Хөхөө Д. (2009). “Ээлжит хичээлийн чанар, түүнийг яаж сайжруулах вэ?. Улаанбаатар
- Чанартай боловсрол хөгжлийн баталгаа. 2001он Илтгэлүүдийн эмхэтгэл. Улаанбаатар
- Чинтогтох Х., Оюун-эрдэнэ М., (2009). “Үйлийн судалгааны арга зүй” .Өндөрхаан

Studying possibilities to develop popular activities of students' learning under experiments

(On the examples of using a workbook which has texts in bi and multi-languages such as Mongolian, Chinese, and English for History subject)

*Bayaraa.D, Tsetsegmaa.D, Naranjargal.N, Suvdandesetseg.E,
Ui Tsai Secondary School*

Abstract

Following questions have been considered in my presentation: Is there any possibility to develop learners' popular activities of learning? Can the multi-lingual workbook of history subject be one of the mentioned possibilities? This research includes: - Analysis on the results from tasks of multi-lingual workbook which was developed under basis of experiments from bilingual and multilingual training methodologies used in different countries, their theories and concepts, and use of workbooks - Results of research that whether this workbook works for developing popular activities of students' learning process under assessments and self-assessments taken by educators and learners Survey and research for the results: - Research subject for history lesson, learning achievements of students, notes from parents' meetings, and analysis and evaluation made on study materials on different countries in academic years of 2016-2017 - Research to reveal interests of recognition, approach, needs and necessities of creative activities of current textbooks used in studies - Research to determine that whether content, level of exercises, needs, and choice of historical materials and its sources included in the multi-lingual workbook used in academic years of 2017-2018 are appropriate for students - Research of whether purpose, direction, percentage of activities by exercise of the multi-lingual workbook is conformed with 4 groups of popular activities Following conclusion was drawn in the result of making comparisons teachers' assessment and self-assessment of students to reveal possibilities to develop learners' popular activities of learning by using multi-lingual workbook. In judging from the assessments of teachers and students multi-lingual workbook has positive influence to develop popular activities of learners and it shows that this is possible to keep using it further. I have a point to continue further experiments and research for possibilities to develop popular activities of learners using above multi-lingual under improving workbook content, form, instructions of exercises, assessment to reveal possibilities to develop, and its criteria, and requirements.

Keywords

The use of multi-lingual learning and exercise case studies and their theories and concepts
